

Захирлын 017 оны 04 дугаар  
сарын 05 -ны өдрийн 142 дугаар  
тушаалын 03 дугаар хавсралт

УХА0559 5919711

## БАГШ НАРЫН ЗААХ АРГЫН НЭГДЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1. Багш нарын заах аргын нэгдэл /ЗАН/-үүд үйл ажиллагаа явуулахдаа энэхүү журмыг баримтлана.
- 1.2. ЗАН-ийн ажлын журмыг багш нарын зөвлөлийн саналыг үндэслэн захирлын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэж захирал баталж мөрдүүлнэ.
- 1.3. Тус сургуульд Байгалийн ухааны, Нийгмийн ухааны заах аргын нэгдлүүд ажиллана.
- 1.4. ЗАН нь боловсролын талаархи төрийн бодлогод нийцүүлэн сургалтын агуулга аргагүйг боловсронгуй болгох, багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажлыг сургууль дээр зохион байгуулах, хичээлийн сургалтын явцад хяналт тавих зэрэг ажлыг явуулна.

### ХОЁР. БАГШ НАРЫН МЭДЛЭГ БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХДАА БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

ЗАН нь багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, багш нэг бүрийн хөгжих нөхцөл бүрдүүлэхэд дараах чиглэлийг баримтлана.

- 2.1. Боловсролын шинэчлэл, мэргэжлийн дидактик, багшийн ёс зүй, дэвшилтэд арга технологийн чиглэлээр шинээр гарч буй шийдвэр, хэрэгжүүлэх арга зүй, шинэ хөтөлбөрүүдийг багш нараар цаг тухайд нь судлуулж, лекц, семинар, ярилцлага зохион байгуулах
- 2.2. Багш нэг бүрээр сургах суралцахуйн, багш хөгжлийн, хөтөлбөрийн агуулгын тодорхой чиглэлээр туршилт, судалгааны ажил хийлгэх, илтгэл тавих, сэдвийн заах арга зүйг оновчтой боловсруулах боломж нөхцөл бүрдүүлж, туслалцаа дэмжлэг үзүүлэх
- 2.3. Багш нарынхаа бүтээлийн үзэсгэлэн гаргах, тайлан уулзалт, нээлттэй болон үзүүлэх хичээл заалгах, ур чадвар дэвшилтэд арга барилыг нь түгээн дэлгэрүүлэх
- 2.4. Багш нэг бүрийн хичээл сургалтын хөтөлбөрөө үр дүнтэй хэрэгжүүлэх ур чадвар, эв дүйг дээшлүүлэх, анги удирдах, хүүхэдтэй ажиллах арга зүйн мэдлэг туршлага бий болгох ажил зохион байгуулах.

ГУРАВ. СУРГАЛТЫН АГУУЛГА, ТЕХНОЛОГИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ  
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХДАА БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

- 3.1. Хичээл бүрийн кабинет, шаардлагатай лабораторийг орчин үеийн шаардлага хэрэгцээ хангасан хүртээмжтэй түвшинд тохижуулах, хичээл сургалтанд байнга үр дүнтэй ашиглах.
- 3.2. Хичээлийн хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах дидактик материал бэлтгэх, сан бүрдүүлэх.
- 3.3. Хичээлийн кабинетуудыг мэргэжлийн сэтгүүл, сурах бичиг, гарын авлага, холбогдох ном, материалаар баяжуулах, системчлэх
- 3.4. Сургалтын техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийг оновчтой хэрэглэхэд анхаарч санаачлагатай, бүртгэл тооцоотой ажиллах.
- 3.5. Суралцагчдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн хичээлийн хөтөлбөр, сургалтын төлөвлөлтөд зарим нэг зохицуулалт хийх ажлыг зохион байгуулах.
- 3.6. Багш бүрийнхээ бүтээлч санаачлагыг дэмжиж, тэдэнд онол арга зүйн зөвлөгөө өгөх.

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ЧАНАР ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.1. Бүлэг сэдэв үзсэний дараа болон улирал, хагас, бүтэн жилийн туршид судалсан агуулгаар суралцагчдаас мэдлэг, чадвар, хөгжлийн түвшин тогтоох шалгалт авч дүнд анализ хийх
- 4.2. Төвшин тогтоох шалгалтын шинжилгээний мөрөөр тодорхой ажил зохион байгуулж үр дүнг тооцох заах аргын нэгдлээрээ хэлэлцэж оновчтой үр дүнтэй ажил, арга барил төлөвлөн хэрэгжүүлэх
- 4.3. Суралцагч нэг бүрийн хөгжил хандлага, мэдлэг, чадварын түвшин, ахиц өөрчлөлтийн судалгаа хийж, харьцуулсан дүгнэлт гаргах, хүүхэд бүрийн онцлогийг харгалзан үзэж шинэ ажил, арга барил төлөвлөн хэрэгжүүлэх
- 4.4. Төрөл бүрийн уралдаан тэмцээн, сэдэвт ажил, хичээлийн олимпиадад бэлтгэл ажлыг зохион байгуулах.

ТАВ. ЗАН-ИЙН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 5.1. Багш нарын ЗАН-ийн бүрэлдэхүүнийг сургуулийн онцлог, бүлгийн болон багш нарын тоо зэргийг харгалзан багш нарын зөвөлгөөний хурлын саналыг үндэслэн захирлын тушаалаар тогтооно.
- 5.2. Гүнзгийрүүлсэн сургалтын чиглэл мэргэжлийн багшийн тоо харгалзан ЗАН-үүд нь секцүүдэд хуваагдан ажиллаж болно.
- 5.3. ЗАН-үүд хуваарийн дагуу 14 хоног тутам нийтээр цуглаж ажлаа явуулна.
- 5.4. ЗАН-ийн ахлагч нь дараах үүрэг хүлээнэ.
  - а) ЗАН-ийн ажлыг улиралаар төлөвлөн батлуулж, хэрэгжилт биелэлтийг сургуулийн захиргаанд тайлагнах.
  - б) Багш нарын ЗАН-ийн ажлын төлөвлөлт биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцох
  - в) Удирдах дээд байгууллага, сургуулийн захиргаанаас гаргасан шийдвэр, дүрэм, журам, удирдамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.